












БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ 2020/1



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2016-2020 ОН	3
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	6
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 ЭРҮҮЛ МЭНД	9
 ГЭМТ ХЭРЭГ	10
 ҮНЭ ХАНШ	12
 АЖ ҮЙЛДВЭР	16
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2019 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	200183	50725	13821	46229	53339	36069
Үүнээс:						
Тэмээ	210	48	-	160	2	-
Адуу	16066	4247	902	3928	3718	3271
Үхэр	16823	4501	1504	3793	4074	2951
Хонь	99691	25368	6864	23491	27723	16245
Ямаа	67393	16561	4551	14857	17822	13602

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I	2017 I	2018 I	2019 I	2020 I
Суурин хүн ам	тоо	28973	28787	29512	29633	
Төрөлт	тоо	31	36	45	56	56
Нас баралт	тоо	11	10	12	16	15
Шилжиж ирсэн	тоо	95	74	65	25	426 ²
Цэвэр өсөлт	хувь	0.07	0.09	0.11	1.13	1.14 ¹

¹ - өмнөх оны суурин хүн амаас тооцов.

² - Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр хязгаарласан Нийслэлийн Засаг даргын захирамжийн хугацаа дууссантай холбоотой шилжилт хөдөлгөөний бүртгэл нэмэгдсэн.


Зураг 1. Нутаг дэвсгэрийн хэмжээ



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистик мэдээгээр 2020 оны 1 сарын эцэст 444 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Үүнээс 16 (3.6%) иргэн нь одоо хөдөлмөр эрхэлж байгаа ба 68 (15.3%) иргэн нь ажлаас чөлөөлөгдсөн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 314 болж өнгөрсөн оноос 2 (0.6%) хүнээр өссөн байна. Тайлант хугацаанд ажил хайж буй иргэдийн 9 (1.9%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг 2. Ажил хайгч иргэдийн хөдөлгөөн




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 126 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 65 (51.6%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Ажил хайгч иргэд, шалтгаанаар



Мөн энэ хугацаанд 28 иргэн ажилд зуучлуулан орсон ба хувьцаат компанид 5, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 8, нөхөрлөл болон төсөвт байгууллагад тус бүр 7, орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 1 иргэн ажилд орсон байна.

Зураг 4. Ажил хайгч иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 154 (34.7%) нь 15-24 насны, 140 (31.5%) нь 25-34 насны залуучууд, 87 (19.6%) нь 35-44 насныхан, 57 (12.8%) нь 45-60 насны, 6 буюу (1.4%) нь 60-аас дээш насны иргэд байна.

Хүснэгт 3. Ажил хайгч иргэд, боловсролоор, I сард

Үзүүлэлт	Ажилгүйдлийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2019 I	2020 I	2019 I	2020 I
Ажилгүйдлийн бүгд	349	444	185	252
Үүнээс:				
Дээд боловсролтой	89	72	64	57
Тусгай дунд боловсролтой	16	18	6	8
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	45	41	17	20
Ерөнхий боловсролтой	185	301	91	165
Бага болон боловсролгүй	14	12	7	2

Ажил хайж буй иргэдийн 72 (16.2%) нь дээд боловсролтой, 18 (4.1%) нь тусгай дунд боловсролтой, 41 (9.2%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 301 (67.8%) нь ерөнхий боловсролтой, 12 (2.7%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 252 (56.8%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 2.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 477.7 (28.4%) сая төгрөгөөр, зарлага 2.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 156.7 (8.4%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 1.3 (61.7%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 171.0 (7.9%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 222.7 (10.3%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 398.4 (18.4%) сая төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 36.2 (1.7%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.

Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар




Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлт	2019	2020	$\frac{2020.I}{2019.I} \%$
	I	I	
Сая төгрөг			
Сангийн орлого, бүгд	1 684.0	2 161.7	128.4
тэтгэврийн сан	1 040.0	1 333.4	128.2

тэтгэмжийн сан	133.0	171.0	128.6
ажилгүйдлийн сан	28.0	36.2	129.3
ҮОМШӨ ¹ -ний сан	173.0	222.7	128.7
ЭМД ² -ын сан	310.0	398.4	128.5
Сангийн зарлага, бүгд	1 855.8	2 012.5	108.4
тэтгэврийн сан	1 564.0	1 762.4	112.7
тэтгэмжийн сан	104.0	72.8	70.0
ҮОМШӨ-ний сан	153.2	144.4	94.3
ЭМД-ын сан	-	-	-
Ажилгүйдлийн сан	34.6	32.9	95.1

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4326 хүнд 1.8 сая төгрөгийн тэтгэвэр, 212 хүнд 72.8 сая төгрөгийн тэтгэмж, 214 хүнд 144.4 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 14 хүнд 32.9 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

байна.

2020 оны эхний 1 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 268.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 386.0 (59.0%) сая төгрөгөөр бүүрсан байна. Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 268.5 (99.3%) сая төгрөг нь улсын төсвөөс, 0.8 (0.3%) бусад орлогоос санхүүжигдсэн


¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

² Эрүүл мэндийн даатгал

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 446 хүнд 76.2 сая төгрөгийн тэтгэвэр, 331 хүнд 27.7 сая төгрөгийн тэтгэмж, 212 жирэмсэн эхчүүдэд 7.9 сая төгрөгийн тэтгэмж, 1134 хүн “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж 55.9 сая төгрөг олгосон байна.

Ахмад дайчин, гавьяат цолтой 15 хүнд 2.3 сая төгрөг, 19 ахмад настанд 1.8 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, 83 хүнд амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 13.7 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэдэд 1.2 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Зураг 7. Нийгмийн халамжийн сангийн зарлагын бүтэц



Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал


Үзүүлэлт	2019	2020	$\frac{2020.I}{2019.I}$ %
	I	I	
	Сая төгрөг		
Сангийн орлого	654.5	268.5	41.0
Улсын төсвөөс	654.0	267.7	40.9
Бусад орлого	0.5	0.8	160.0
Сангийн зарлага	536.3	186.8	34.8
Тэтгэвэр	63.6	76.3	120.0
Тэтгэмж	19.5	27.7	142.1
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	13.3	13.7	103.0
"Алдарт эх" I одонт эхчүүд	118.1	-	0.0
"Алдарт эх" II одонт эхчүүд	113.5	-	0.0
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	7.4	7.9	106.8
Насны хишиг	102.7	-	0.0
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	2.6	2.3	88.5
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	2.1	1.8	85.7
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	2.3	1.2	52.2
“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр	37.4	-	0.0
Цалинтай ээж	53.8	55.9	103.9



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2020 оны эхний 1 сард 60 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 13 (27.6%) хүүхдээр өссөн байна. Энэ хугацаанд 34343 хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 17179 (2 дахин) хүнээр өссөн бол хэвтэн эмчлүүлсэн 948 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 137 (16.9%) хүнээр өссөн байна.


Зураг 8. Амбулаторийн үзлэг 2020 оны I сар



Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл эхний 1 сард

Үзүүлэлт	2019 I	2020 I	$\frac{2020.I\%}{2019.I}$
Амаржсан эхийн тоо	47	60	127.7
Үүнээс бусад аймгийн харьяат	15	20	133.3
Амьд төрсөн хүүхэд	46	60	130.4
Үүнээс бусад аймгийн харьяат	15	20	133.3
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	-	1	-

Зураг 9. Халдварт өвчин, сараар



2020 оны эхний 1 сард халдварт паразит өвчний 23 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 51.1%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 14 (155.6%) тохиолдлоор, цочмог

халдварт өвчний 22 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 48.9%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 13 (144.4%) тохиолдлоор тус тус өссөн байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 15.4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.3 продицмиллээр өссөн байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2019 I	2020 I	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	9	23	14
Заг хүйтэн	5	17	12
Тэмбүү	2	2	-
Мөөгөнцөр /кандидоз/	2	-	-2
Трихомониаз	-	4	4
Цочмог халдварт өвчин	9	22	13
Цусан суулга	-	5	5
Гепатит А	-	1	1
Салхин цэцэг	6	14	8
Сальмонеллез	-	1	1
Сүрьеэ	3	-	-3
Нийт халдварт өвчин	18	45	27



ГЭМТ ХЭРЭГ

2020 оны эхний 1 сард дүүргийн хэмжээнд 9 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18 (66.7%) хэргээр буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 11.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.6 пунктээр доогуур үзүүлэлт юм.

Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2019 I	2020 I	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	27	9	-18	-66.7	100.0
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	9	5	-4	-44.4	55.6
Бусдын эд хөрөнгө хулгайлах	6	2	-4	-66.7	22.2
Бэлгийн халдашгүй байдал	3	0	-3	-100.0	0.0
Залилан мэхлэх	3	1	-2	-66.7	11.1
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	2	0	-2	-100.0	0.0
Хүний амь нас хохирсон /10.4-10.6/	3	1	-2	-66.7	11.1
Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх	1	0	-1	-100.0	0.0
Хэрэг илрүүлэлтийн хувь	21.7	11.1			


Зураг 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар




Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 5 (55.6%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 2 (22.2%) нь бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэгүүд байна.

Тайлант хугацаанд хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 5, бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг 2, залилан мэхлэх хэрэг, хүний амь нас хохирсон хэргүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.

Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар



Зураг 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний I сард




Хүснэгт 9. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2019 I		2020 I	
	Согтуугаар	Гудамж талбайд	Согтуугаар	Гудамж талбайд
Бүгд	5	4	1	1
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	5	4	1	
Бусдын эд хөрөнгө хулгайлах	-	-	-	1
Дүнд эзлэх хувь	18.5	14.8	11.1	11.1

Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг болон 1 болж өмнөх оны мөн үеэс 4 (80.0%) хэргээр, гудамж талбайд 1 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 (75.0%) хэргээр тус тус буурсан байна. Мөн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 11.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.4 пунктээр, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 11.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 13. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн I сар



ҮНЭ ХАНШ

2020 оны 1 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 10. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2020 оны 1 сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжээ кг	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг супер маркет
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1 425	1 500		1 500
	I зэрэг	кг	1 100	1 200		1 200
	II зэрэг	кг	900	950		900
Будаа	цагаан	кг	2 500	2 400		2 400
	шар	кг	3 525	3 525		3 550
Хонины мах	ястай	кг			8 063	
	цул	кг			9 563	
Үхрийн мах	ястай	кг			10 563	


	цул	кг				12 938	
Адууны мах, ястай		кг				8 363	
Ямааны мах		кг				7 063	
Элсэн чихэр		кг	2 200	2 200			2 100
Сүү /задгай/		л	1 800				
Тараг /задгай/		л	-				
Цэцгийн тос, Орос		кг	4 000	4 000			4 000
Байцаа		кг				1 800	
Манжин		кг				3 000	
Төмс	монгол	кг				9 000	
Лууван	монгол	кг				1 500	
Сонгино	хятад	кг				2 500	
	монгол	кг				3 500	
Сармис, булцуу		ш				300	
Огурцы, хятад		кг				6 500	
Помидор, хятад /үрлэн/		кг				6 500	
Ургамлын тос/ sunny gold/		ш	4 400	4 400			4 500
Өндөг		ш	400	380			350
Талх	Есөн шанд	том 900 гр	ш	1 800	1 800		1 800
		Дунд 700 гр	ш	1 700	1 700		1 700
		жижиг 500 гр	ш	1 100	1 100		1 100
	Атар талх		ш	1 150	1 200		1 200

Хүснэгт 11. Үйлчилгээний үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)


Үзүүлэлт	Хэмжин нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Дулаан	1м ²	660	1м ³	1632
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000		
	40м ² - 80м ²	5 000	-	-
	81м ² -аас дээш	10 000		
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)		1 гкал
		1м ³ (тоолууртай)	3 162	
	Зун	1 хүн (тоолуургүй)	1 632	
		1м ³ (тоолууртай)	4 428	
Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	1 632	1 л (тоолуургүй)	76 611
	1 хүн (тоолуургүй)	0.8	1 л (тоолууртай)	1.50
	1 л (тоолууртай)	0.65	1 л (тоолууртай)	1.20
Бохир ус*	сүүр хураамж	1 800	1 л (зөөврөөр)	5.45
	1 хүн (тоолуургүй)	0.99	1 л (тоолуургүй)	1.8
	1 л (тоолууртай)	0.73	1 л (тоолууртай)	1.4

* 2019 оны 9 сарын 15-нээс мөрдөж байгаа тариф

Зураг 14. “Алтан тариа” гурилын дундаж үнэ, жил бүрийн 1-р сард



Зураг 15. Нэг кг махны дундаж үнэ, жилийн бүрийн 1-р сард



Хүснэгт 12. Цахилгааны үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	102.9
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	122.7
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	108.8
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	81.6
Сарын сүүр тариф	төг/сар	2 000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай /бусад үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	133.0
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	214.3
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	81.6
3 тарифт тоолууртай /уул уурхай, боловсруулах аж үйлдвэр/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

* 2019 оны 5 сарын 1-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 13. Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ


	2018 I	2019 I	2020 I
	төгрөг		
Адууны шир	23 000	19 000	9 000
Үхрийн шир /2.3 метрээс доош/	20 000	7 500	5 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	38 000	15 000	8 500
Хонины арьс	4 000	2 000	1 000
Ямааны арьс	20 000	38 000	30 000

Хүснэгт 14. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2016 I	2017 I	2018 I	2019 I	2020 I	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 440	1 440	1 508	1 738	1 810	72	4.1
АИ -92,93	1 540	1 540	1 654	1 813	1 860	47	2.6
Дизель түлш	1 650	1 650	1 781	2 328	2 490	162	7.0

2020 оны 1 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 47 төгрөгөөр (2.6), АИ-80 бензин 72 төгрөгөөр (4.1), дизель түлш 162 төгрөгөөр (7.0) тус тус өссөн байна.

Зураг 16. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ, (чиглэл: УБ-БН, БН-УБ)






АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2020 оны эхний 1 сард 15.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.5 (8.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 15. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2019 I	2020 I	$\frac{2020}{2019}\%$	2019 I	2020 I	$\frac{2020}{2019}\%$
Нүүрс олборлолт	м.тн	520.0	441.4	-78.6	16 380.0	14 786.9	-1 593.1
Дулаан дамжуулалт	м.гкал	26.1	26.3	0.2	747.8	829.7	81.9
Талх үйлдвэрлэлт	тн	7.9	19.1	11.2	10.8	26.7	15.9
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	12.9	4.8	-8.1	58.7	32.3	-26.4
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт		566.9	491.6	-75.3	17 197.3	15 675.6	-1 521.7

Зураг 17. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар




Оны эхний 1 сарын байдлаар нүүрс олборлолт биет хэмжээгээр 78.6 (15.1%) мянган тонн, үнийн дүнгээр 1593.1 сая төгрөгөөр буурсан байгаа нь түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон Засгийн газрын 2018 оны 62 тогтоолтой холбоотойгоор эрэлт буурсан. Харин дулаан үйлдвэрлэлт биет хэмжээгээр 0.2 (0.8%) мянган гкал-аар өссөн ч үнийн дүнгээрээ 81.9 (10.9%) тонноор өссөн байгаа нь дулааны үнийг өнгөрсөн онд нэмсэнтэй холбоотой байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт 11.2 (2.4 дахин) тонноор өсч, нарийн боовны үйлдвэрлэлт 8.1 (58.7) тонноор буурсан байгаа нь өнгөрсөн онд сар шинийн баяр 2 сарын эхээр тохиож байсан учир хэвийн боовны үйлдвэрлэлтийн ихэнх нь 1 сард хийгдсэнтэй холбоотой байна.

Зураг 18. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, сая төгрөг



Зураг 19. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн I сард



Тайлант сарын байдлаар 1 кг талхны үнэ 1397.9 төгрөг байгаа нь өнгөрсөн оны түвшинд байгаа бол 1 кг нарийн боовны үнэ 6729.2 төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 2178.8 (47.9%) төгрөгөөр нэмэгдсэн байна.




НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 213.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 98.3 (85.5%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 99.3 (45.6%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 16. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

Үзүүлэлт	2019 I	2020 I	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	115.0	213.3	98.3
Орон сууц	17.6	56.9	39.3
Ус борлуулалт, бүгд	58.9	76.3	17.4
Хүн амд	33.0	37.5	4.5
Аж ахуйн нэгжид	25.9	38.8	12.9
Сувагжуулалт	33.5	68.5	35.0
Бусад	5.0	11.5	6.5

Зураг 20. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 17. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	45 337.5	31 661.3	69.8
Тавлаг өргөө	8 250.5	5 123.0	62.1
Маргад өргөө	8 793.9	6 608.2	75.1
Сод хөгжил	10 819.6	8 562.2	79.1
Шинэ элч	8 625.7	5 805.5	67.3
Уурхайчин	4 160.0	3 036.8	73.0
Содон суварга	4 687.8	2 525.6	53.9

ИРГЭДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ



**ГАРАА САЙТАР
САВАНДАЖ УГААХ**



**ОЛОН ХҮН ЦУГЛАРСАН
ГАЗРААР ЯВАХГҮЙ БАЙХ**



**ГАДУУР ЯВАХДАА
БЭЭЛИЙ ӨМСӨХ**



**БОХИР ГАРАА АМ, ХАМАР,
НҮДЭНДЭЭ ХҮРГЭХГҮЙ,
НУХАХГҮЙ БАЙХ**



**ХАНИАЖ, НАЙТААЖ
БАЙГАА ХҮНЭЭС ХОЛ БАЙХ**



**БУХИМДАХГҮЙ
ТАЙВАН БАЙХ**



**ХАЛУУН, БҮЛЭЭН
ШИНГЭН ИХЭЭР УУХ**



**АМНЫ ХААЛТ
ХЭРЭГЛЭХ**



**ӨГЛӨӨ, ОРОЙД СОД,
ДАВС, САРМИС,
ЦАРВАНГИЙН
УУСМАЛЫН АЛЬ НЭГЭЭР
ХООЛОЙГ ЗАЙЛАХ**



**БУСАДТАЙ ГАР
БАРИХ, ҮНСЭХЭЭС
ЗАЙЛСХИЙХ**



**ТҮҮХИЙ УС УУХГҮЙ
БАЙХ**



**НУС, ЦЭР, ШҮЛСЭЭ
ИЛ ЗАДГАЙ
ХАЯХГҮЙ БАЙХ**



WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛООМ 

Валютын ханш 




©2017


аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn